

Батлав:
Огноо: 2014 он 5 сар 5 өдөр

МУИС-ийн Сургалтын нэгдсэн
албаны дарга: Д-р, Ч.УНДРАМ

Хичээлийн хөтөлбөр боловсруулах заавар

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Хичээлийн хөтөлбөр нь сургалтын хөтөлбөрт тусгагдсан хичээл тус бүрээр суралцагчийн эзэмшвэл зохих онол, практик мэдлэг, чадварын агуулга, сэдэвчилсэн төлөвлөгөө, үнэлгээ, арга зүй, тухайн хичээлийн багтаамж/багц цаг, индекс, ашиглавал зохих ном, сурах бичиг, эх сурвалжийн жагсаалтыг тодорхойлсон баримт бичиг мөн.

1.2 Сургалтын хөтөлбөрт оруулах хичээлийн хөтөлбөрийг, тухайн хичээлийг хариуцсан мэргэжлийн тэнхимээс эрх олгосон мэргэжлийн багш нар боловсруулж, төслийг тэнхим/сургуулийн хөтөлбөрийн дэд хороогоор хэлэлцэж бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын албаны эрхлэгч хянана. Хичээлийн хөтөлбөрийг 2 -оос доошгүй багш хамтран боловсруулна.

1.3 МУИС-ийн Ерөнхий суурь хичээлийн хөтөлбөрийг Ерөнхий суурь хөтөлбөрийн дэд хороо хэлэлцэж МУИС-ийн Хөтөлбөрийн ерөнхий хороо баталгаажуулна.

1.4 Ерөнхий суурь хичээлийн хөтөлбөрт өөрчлөлт хийх шаардлага гарвал Ерөнхий суурь хөтөлбөрийн дэд хороо төлөвлөгөөг өөрчлөх үндэслэлийг шинэ хувилбарын хамт МУИС-ийн Хөтөлбөрийн ерөнхий хороогоор хэлэлцүүлэн баталгаажуулна.

1.5 Мэргэжлийн хичээлийн хөтөлбөрийг шаардлагатай гэж тухайн сургууль\тэнхмийн хөтөлбөрийн дэд хороо зохих өөрчлөлт оруулж, цаг тухай бүр боловсронгуй болгож болно. Ингэхдээ МУИС-ийн Хөтөлбөрийн хорооны түр журмын холбогдох заалтыг баримтлах бөгөөд бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын албаны эрхлэгчид урьдчилан мэдэгдэнэ.

Хоёр. Хичээлийн хөтөлбөр дэх нэр томъёо, үндсэн ойлголтууд

2.1 *Хичээлийн нэр*: Сургалтын хөтөлбөрт тусгагдсаны дагуу бичих ба товч, тодорхой, товчлоогүй байна. Хичээлийн нэрийг хичээлийн хөтөлбөрт Монгол болон Англи хэлээр бичсэн байна.

2.2 *Хичээлийн индекс*: Хичээл нь тусгай ялгах индекстэй байна. Индекс нь тухайн шинжлэх ухааны салбарын ерөнхий Англи нэрний эхний 4 үсэг ба 3 оронтой тооноос бүрдэх бөгөөд эхний тоо нь уг хичээлийн ангиллыг, дараагийн хоёр тоо нь хичээлийн дугаар (хичээл хоорондын залгамж холбоо, дэс дарааллыг харгалзан тогтоогдсон) –ыг илэрхийлнэ. Үүнд:

001-099 дугаартай бол багц цаг олгохгүй хичээл

100-199 дугаартай бол МУИС-ийн Бакалаврын хөтөлбөрийн Ерөнхий суурь хичээл

200-299 дугаартай бол Бакалаврын хөтөлбөрийн Мэргэжлийн заавал судлах хичээл

300-399 дугаартай бол Бакалаврын хөтөлбөрийн Чөлөөт сонголтын хичээл
600-699 дугаартай бол Магистрын хөтөлбөрийн заавал судлах хичээл
700-799 дугаартай бол Докторын хөтөлбөрийн заавал судлах хичээл
800-899 дугаартай бол Магистр, Докторын хөтөлбөрийн сонгон судлах хичээл
гэж үзнэ. МУИС-д заагдах хичээлүүдийн индекс өөр хоорондоо давхцахгүй. Ижил
индексгүй хичээлүүдийн нэр болон багц цаг адилхан байна.

2.3 Хичээлийн ангилал: Тухайн хичээл нь Бакалавр, Магистр, Докторын аль хөтөлбөрт
хамаарахаас гадна, Бакалаврын хөтөлбөрийн хувьд: “Ерөнхий суурь”, “Мэрэгжлийн
заавал судлах”, “Чөлөөт сонголт”-ын, Магистр, Докторын хөтөлбөрийн хувьд: “Заавал
судлах”, “Сонгон судлах”-ын аль нь болохыг тодорхойлно.

2.4 Хичээлийн багц цаг: Багц цаг нь хичээлийн агуулгын багтаамжийг илэрхийлсэн бүхэл
тоо байх ба долоо хоногт тухайн хичээлийг судлах цаг, хэлбэрээс хамааран 2-3 багц цаг
байх нь зохимжтой гэж үзнэ. Тухайн хичээлийн багц цагт лекц, семинар, лаборатор, бие
даалтын цагийн харьцааг тодорхойлж өгнө.

2.5 Судлах улирал: Тухайн хичээлийг судлах улирлыг заах ба нэг хичээлийг нэг улиралд
судлахаар төлөвлөнө. Агуулгын багтаамжаас шалтгаалан хоёр ба түүнээс дээш улирал
дараалан, эсвэл дараалсан бус улиралд заагдахаар хичээл байвал түүнийг агуулгын
залгамж холбоо бүхий тусдаа хичээлүүдэд хувааж, тус бүрд нь нэр, индекс, багц цаг
онооно. Хичээлийн эрэлт хэрэгцээ, анги танхим, заах багшаас шалтгаалан хичээлийг аль
улиралд судлах боломжтойг Хөтөлбөрийн дэд хороод Сургалтын нэгдсэн албатай хамтран
шийднэ.

2.6 Хичээлийн залгамж холбоо: Хичээлийн залгамж холбоог Хөтөлбөрийн дэд хороод
хэлэлцэж Хөтөлбөрийн ерөнхий хороогоор батлуулах бөгөөд зөвхөн агуулгын хувьд
зайлшгүй уялдаатай бүлэг хичээлүүдийн хувьд залгамж холбоо тогтооно. Тухайн
хичээлийг судлахын тулд өмнө нь заавал судалж, амжилттай үнэлэгдсэн байх хичээлийн
нэр, индекс, багц цагийг бичнэ. Мөн тухайн хичээлийн дараа судалвал зохих, залгамж
холбоо бүхий хичээлийг зааж өгч болно.

2.7 Хичээлийн зорилго: Энд сурах үйлийн эцсийн буюу хүрэх гэж эрмэлзэж буй үр дүнг
тодорхойлсон, цогц чадамжийг илэрхийлсэн ерөнхий томъёолол байна. Хичээлийн
зорилго нь суралцагчийн “Би яагаад энэ хичээлийг сонгон судлах хэрэгтэй вэ?” гэсэн
асуултад хариулахад чиглэнэ.

2.8 Хичээлийн агуулга: Энэ хэсэг нь хичээлийн хөтөлбөрийн гол цөм хэсэг бөгөөд
эзэмшвэл зохих мэдлэг, чадварыг ямар зохион байгуулалттайгаар олгох тухай цогц,
ерөнхий ойлголт юм. Тухайн хичээлээр судлах шинжлэх ухааны
ухагдахуун/судлагдахуун, түүний дэс дарааллыг тодорхойлж, 50-100 үгэнд багтаан
Монгол болон Англи хэлээр бичнэ. Тухайн хичээлийн агуулга нь өөр/бусад хичээлүүдийн
агуулгатай давхцах ёсгүй.

2.9 Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар: Энд тухайн хичээлийг судалж дууссанаар оюутны эзэмшсэн байх мэдлэг, чадварыг жагсааж суралцагчийн “Би тус хичээлийг судалснаар юу сурах вэ?” гэсэн асуултад хариулахад чиглэсэн байна.

а) Бакалаврын хичээлээр оюутанд эзэмшүүлэх мэдлэг, ур чадварыг ерөнхий болон мэргэжлийн мэдлэг, чадвараар ангилан тодорхойлно. Үүнд:

- Ерөнхий мэдлэг, чадварын хүрээнд оюутанд амьдарч буй нийгэм, байгалийн орчны юмс үзэгдэл, харилцаа холбооны тухай шинжлэх ухаанч, рациональ мэдлэгтэй, логикоор сэтгэдэг бие хүнийг бэлтгэх, өөрийн боловсрол, мэргэжлийн мэдлэг чадварыг амьдрал дээр амжилттай хэрэгжүүлэх ур чадвар эзэмшсэн, нийгмийн идэвхтэй гишүүн болж хөгжихөд нь хэрхэн суралцуулах тухай бичнэ.
- Мэргэжлийн мэдлэг, чадварын хүрээнд оюутанд шинжлэх ухааныг одорхой чиглэлээр онол, парктикийн мэдлэг олгохоос гадна асуудал шийдвэрлэх, логик сэтгэлгээ, таамаглах, нотлох, няцаах үндэслэлийг тайлбарлах зэрэг чадварууд эзэмшихийг нэрлэж болно.

б) Магистр, Докторантын хичээлээр суралцагчдад эзэмшүүлэх мэдлэг, ур чадварыг ерөнхий болон мэргэжлийн мэдлэг, чадвараар ангилан тодорхойлно. Үүнд:

- Ерөнхий мэдлэг, чадварын хүрээнд суралцагчдад судалгаа хийх, тодорхой сэдвийн хүрээнд таамаглал дэвшүүлэх, судалгааны асуултад хариулах тоон болон чанарын шинжилгээ хийж дүгнэн боловсруулах мэдлэг, чадварыг өндөр түвшинд эзэмшүүлэх зорилготой байх нь зохистой.
- Мэргэжлийн мэдлэг, чадварын хүрээнд суралцагчид тухайн шинжлэх ухааны чиглэлээр сүүлийн үеийн олон улсын болон Монгол эрдэмтдийн дэвшүүлсэн онол, парктикийн асуудлуудын талаар мэдлэг, чадвар эзэмшүүлж, тухайн чиглэлээр нэмэлт судалгаа хэрхэн хийх чиглэл олгох тухай байж болно.

2.10 Хичээлийн сэдэвчилсэн төлөвлөлт: Энэ хэсэгт тухайн хичээлийн лекц, семинар, лаборатор, оюутны бие даан гүйцэтгэх ажлын сэдэв, агуулга, олгох мэдлэг, чадварын задаргаа, судлах цаг, дараалал, тухайн сэдвийн хүрээнд ашиглах ном сурах бичиг, унших материал зэргийг тодорхой бичнэ. Мөн тухайн хичээлээр улирлын явцад болон төгсгөлд авах шалгалтын тоо, давтамж, огноог оруулж өгсөн байна.

2.11 Лекцийн хичээл: Суралцагчдад тодорхой хугацаанд шинжлэх ухааны онолын суурь мэдлэгийг системтэй өгөх зорилготой багшийн тайлбарлан ярих болон сурган хүмүүжүүлэх арга, хэрэгслийг хэрэглэж буй сургалтын зохион байгуулалтын хэлбэр.

2.12 Семинарын хичээл: Суралцагчийн мэдлэгийг тэлэх, илүү нарийвчлах, мэргэжлийн үйл ажиллагааны чадварыг сургаж бэхжүүлэхэд чиглэгдсэн сургалтын зохион байгуулалтын хэлбэр.

2.13 Лабораторийн хичээл: Суралцагчийн онол-арга зүйн мэдлэг, практик чадварын холбоог мэргэжлийн үйл ажиллагааны бодит орчинд болон түүнтэй төстэй нөхцөлтэй холбож зохион байгуулсан сургалтын хэлбэр.

2.14 Оюутны бие даан гүйцэтгэх ажил: Суралцагч бие даан эх сурвалжаас шинэ мэдээллийг олж авах, бие дааж сургалтыг төлөвлөж, зохион байгуулах чадвартай болох,

хүссэн цаг үедээ тохирсон аргаар мэдлэгээ баяжуулах боломжийг олгож байгаа сургалтын арга юм.

2.15 Хичээлийн үнэлгээ (идэвх, явц, шалгалтынооо): Хичээлийн явцад суралцагчдад олгосон мэдлэг, чадварыг үнэлэх давтамж, хэлбэр /бичгээр, амаар, тестээр г.м/, мөн улирлын эцэст үнэлэн дүгнэх арга хэлбэр, шалгуур үзүүлэлт, дүрмийг тодорхой дурдана. Эзэмшүүлсэн мэдлэг, чадвар тус бүрээр нарийвчлан задалж, үнэлгээний аргачлалыг бичнэ. Мөн тухайн хичээлийг судлахад суралцагчид тавих нэмэлт шаардлагуудыг тодорхой бичнэ.

2.16 Хичээл заа хбагш, тэнхим: Тухайн хичээлийг хариуцах мэргэжлийн тэнхим/сургууль, заах багш нарын нэр, холбоо барих хаяг, эрдмийн цол зэрэг, суралцагчид зөвлөгөө өгөх цагийн хуваарь зэргийг тодорхой бичнэ. (*Хичээлийг хоёр ба түүнээс дээш багш заах, сонголтыг суралцагчид өгөхийг эрмэлзэх ёстой бөгөөд мэдээллийг СИСИ-д оруулах*)

2.17 Ашиглах ном, сурах бичиг, материал: Энд тухайн хичээлийн үндсэн сурах бичиг, ном, нэмэлт унших материал, цахим хуудасны жагсаалтыг бичнэ.

Гурав. Хичээлийн хөтөлбөрийн жишиг загвар (СИСИ-д оруулах)

Загвар

ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

[.....ХИЧЭЭЛИЙН НЭР (Монгол, Англихэлээр).....]

Хичээлийн индекс:

Хичээлийн ангилал:

Хичээлийн багц цаг: (лекц/сем/лаб/биедаалт)

Судлах улирал:

Хичээлийн хөтөлбөр боловсруулсан..... тэнхим/сургуулийн хөтөлбөрийн дэд хорооны дарга:

..... (гарын үсэг)(нэр) /цол, зэрэг/

Хянасан бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн дэд хорооны дарга:

..... (гарын үсэг)(нэр) /цол, зэрэг/

Хичээл заах багш/тэнхмүүд:

Тэнхим			
Багшийн нэр, цол, зэрэг			
Утас			
Цахим шуудан			
Байр, өрөө			
Зөвөлгөө өгөх өдөр, цаг			
Цахим хуудас			

ХИЧЭЭЛИЙН ЗАЛГАМЖ ХОЛБОО

[Энд энэхүү хичээлээс өмнө заавал судалсан байх хичээлийг /нэр, индекс, багц цаг/ жагсаан бичнэ. Мөн тухайн хичээлийн дараа судалвал зохих хичээлийг бичиж болно.]

ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

[Хичээлийн зорилго бол сурах үйлдлийн эцсийн үр дүн буюу хүрэх гэж эрмэлзэж буй үр дүнг илэрхийлсэн, цогц чадамжийн ерөнхий томъёолол юм. Түүнчлэн энэ хэсэгт суралцагч тус хичээлийг сонгох хэрэгцээ шаардлагыг хичээлээр үзэх сэдвүүдийн хүрээнд бичнэ]

ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

[Тухайн хичээлийн агуулгыг 50-100 үгэнд багтаан монгол болон англи хэлээр бичнэ]

ХИЧЭЭЛЭЭР ЭЗЭМШИХ МЭДЛЭГ, ЧАДВАР

[Энд тухайн хичээлийг судалж дууссанаар оюутны эзэмшсэн байх мэдлэг, чадварыг жагсаан бичих бөгөөд, мэдлэгийг хэрэглэх, ашиглах, аливаа асуудлыг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх чадварыг оруулсан байна]

ХИЧЭЭЛИЙН СЭДЭВЧИЛСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

[Дараа хүснэгтийн дагуу дээр дурдсан мэдлэг, чадварыг хэрхэн олгох талаар хичээлийн сэдэвчилсэн төлөвлөлтийг хийх ба лекц, семинарын хичээлийн сэдэв бүрээр агуулгыг товч бичнэ. Мөн тухайн сэдвийн хүрээнд эзэмшүүлэх мэдлэг, чадвар, ашиглах ном, эх сурвалжийг тодорхой бичнэ.]

Лекц, семинар, лаборатор:

Долоох оног	Хичээлийн сэдэв, хэлбэр (лекц/сем/лаб)	Сэдвийн агуулга, олгох мэдлэг, чадвар	Тухайн сэдэвт заавал ашиглах ном, эх сурвалжийн жагсаалт (бүлэг, хуудасны дугаар)	Цаг
I				
II				
III				
IV				
V				
VI				
VII				
VIII				
IX				
X				
XI				
XII				
XIII				
XIV				

XV				
XVI				
Нийт				

ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ (идэвх, явц, шалгалт)

[Энд тухайн хичээлийн ерөнхий болон сэдэв бүрээр эзэмшүүлсэн мэдлэг, чадварыг хэрхэн үнэлэх /рубрик/ талаар тодорхой бичиж өгнө. Ялангуяа улирлын явцын болон эцсийн шалгалтын огноог бичиж өгсөн байх]

ХИЧЭЭЛЭЭР АШИГЛАХ НОМ СУРАХ БИЧГИЙН ЖАГСААЛТ

[Энд тухайн хичээлийн үндсэн сурах бичиг, ном, нэмэлт унших материалын жагсаалтыг бичнэ. Мөн нэмж ашиглаж болох гарын авлага, эрдэм шинжилгээний өгүүлэл, мэргэжлийн болон сар, улирал, жил тутмын сэтгүүл, тоо мэдээллийн эмхэтгэл, цахим хуудас зэргийг жагсааж болно]

